

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 4.1.2 дахь заалтын “хувь” гэсний дараа “байх бөгөөд энэ журмын 4.1-д заасан дүрмийн сангийн хөрөнгийг банкин дахь харилцах дансанд байршуулахдаа арилжааны нэг банкинд 30 хувиас хэтрэхгүйгээр байршуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктэй болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай, даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө байршуулахаар бол дүрмийн сангийн нийт хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүйгээр байршуулна” гэж мөн журмын 5.3.2 дахь хэсгийн “хувь” гэсний дараа “байх бөгөөд энэ журмын 5.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг арилжааны банкин дахь харилцах дансанд байршуулахдаа нэг банкинд 20 хувиас хэтрэхгүйгээр байршуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктэй болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай болон даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө байршуулахаар бол нөөц сангийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүйгээр байршуулна” гэж тус тус нэмсүгэй.

2. “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 5.1 дэх заалтын “тухайн тайлант жилд байгуулсан”, “болон учирч болзошгүй хохирлын хуримтлагдсан нөөц санг 100 хувь” гэснийг, мөн шаардлагын 5.3 дахь заалтын “тухайн тайлант жилд байгуулсан”, “хувь болон учирч болзошгүй хохирлын хуримтлагдсан нөөц сангийн 100” гэснийг тус тус хассугай.

3. “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 5.5 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ